

“Ч.ДАЛАЙ -80” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Шинжлэх ухааны академи, Олон улс судлалын хүрээлэн хамтран Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, доктор, профессор ЧУЛУУНЫ ДАЛАЙ агсны 80 насны ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлыг Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, Олон улс судлалын хүрээлэн, МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургууль болон Ч.Далайн гэр бүлийнхэн, үр хүүхдүүд хамтран 2010 оны 11 сарын 29-ний өдрийн д.аваа гарагийн 14.00 цагт МУИС-ийн төв байрны Эрдмийн өргөөнд зохион байгууллаа.

Хурлыг ШУА-ийн Дэд Ерөнхийлөгч Т.Дорж даргалан явуулж ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Б.Энхтүвшин, ОУСХ-ийн захирал, доктор, профессор Л.Хайсандай нээж үг хэлэв.

Хуралд “Дэлхийд нэртэй эрдэмтэн, академич Ч.Далай”, “Академич Ч.Далай ба Монголын Ойрад судлал”, “Академич Ч.Далайн нэгэн бүтээлийн тухай”, “Ч.Далай Монголын бөө судлалд” “Монгол Хятадын соёлын харилцааны түүх” сэдэвт илтгэлүүдийг тавьж хэлэлцүүлсэн.

Мөн хурлын үйл ажиллагаанд амжилт хүсч гадаад, дотоодоос ирүүлсэн илгээлт, мэндчилгээг уншиж танилцуулжээ. Академич Ч.Далай гуайн үр хүүхдүүд эрдэмтний бүтээл туурвилыг олон нийтэд хүргэх, шинэ залуу үеийхэнд эрдэм судлалынх нь ажлыг түгээн дэлгэрүүлэх, зохиогчийн эрхтэй холбогдох үйл ажиллагааг нь эрчимжүүлэх зорилгоор “Эрдмийн Далай” Төрийн бус байгууллага байгуулсан байна. Хурлын үеэр ШУА, Түүхийн хүрээлэн, “Тод номын гэрэл” ТББ зэрэг байгууллагууд Ч.Далайн гэр бүлийн хүн А.Норолхоо гуайд хүндэтгэл үзүүлсэн байна.

Хурлын үеэр академич Ч.Далай агсны бүтээлийн болон гэрэл зургийн бэсрэг үзэсгэлэн ажиллуулж хуралд оролцогсад болон оюутан залуучуудад сонирхуулсан байна.